

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 12-р сарын 25-ны өдөр

№ 21/01

Улаанбаатар хот

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 15 цагт эхэлж ТУЗ-ийн гишүүд, компанийн гүйцэтгэх захирал, Тооллогын комиссын гишүүд Шангри-Ла оффис-н 801 тоотод, Хувьцаа эзэмшигчид Зүүм /ZOOM/ платформоор хуралд орж ирлээ.

Хурал зохион байгуулах комисс хурлыг холбогдох журамын дагуу зохион байгуулсан ба тооллогын комисс хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэн авч нийт ирцийг танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит бус хуралд 75,000 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 82,871 ширхэг энгийн хувьцааны 90.5% болж байгааг хуралд оролцогч болон хурлын даргад мэдээлэв. Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулж, хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай комиссын тогтоолыг уншиж сонсгов.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дарга Баянмөнхийн Сугарсүрэн хурлыг нээж хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэд талархал илэрхийлэв. Мөн тэрээр хурлаар хэлэлцэх дараах асуудлуудыг танилцуулав.

1. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинэчлэн сонгох;
3. 2022 оны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг танилцуулах;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлах;

Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн материал хувьцаа эзэмшигчдэд урьдчилан хүргэгдсэн бөгөөд Хурлын дарга доорх өөрчлөлтүүдийг дурдаж, өөрчлөлт оруулж байгаа шалтгааныг тайлбарлав. Үүнд:

1. Компанийн дүрмийн 2.2–р зүйлийг “ХК нь шаардлагатай тохиолдолд хууль, журмын дагуу төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулна” болгон өөрчлөх;
2. Компанийн дүрэмд 2.4–р зүйлээр “Компанийн тухай хуулийн 6.7-д заасан эрхийн дагуу охин компанийн хувьцаа эзэмшигчдийн гаргасан гомдлын дагуу охин компанийн өрийг хамтран хариуцахаар шүүхийн шийдвэрээр тогтоосноос бусад тохиолдолд охин компанийн өрийг хариуцахгүй” гэсэн заалт нэмж оруулах;
3. Компанийн дүрмийн 3.3.1–р зүйлийг “Байгалийн болон таримал ургамал, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн толгой компанийн үйл ажиллагаа; 7010” болгон өөрчлөх;
4. Компанийн дүрмийн 3.3.2–р зүйлийг “Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа; 7010” болгон өөрчлөх;

5. Компанийн дүрмийн 3.4-р зүйлийг “Үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор бэлтгэлийн нэгдсэн сүлжээнд оролцогч болон хувьцаа эзэмшигчдэд санхүүгийн, менежмент, хөрөнгө оруулалт хийх замаар хуримтлал бий болгох мэдлэг мэдээллийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа явуулах зэргээр хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа явуулна” болгон өөрчлөх;
6. Компанийн дүрмийн 7.10-р зүйлийг “Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийг сонгоно. ТУЗ нь компанийн болон охин компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хяналт тавих үүрэг гүйцэтгэнэ” болгон өөрчлөх;
7. Компанийн дүрэмд 7.23.21-р зүйлээр “Охин компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэсэн заалт нэмж оруулах;
8. Компанийн дүрмийн 7.37.1-р зүйлийг “Компанийн болон охин компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих” болгон өөрчлөх;
9. Компанийн дүрмийн 7.38.1-р зүйлийг “ТУЗ-ийн гишүүн, компанийн болон охин компанийн гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоож, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгах” болгон өөрчлөх;
10. Компанийн дүрмийн 7.38.5-р зүйлийг “Компанийн болон охин компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг тодорхойлох” болгон өөрчлөх;
11. Компанийн дүрмийн 7.41.1-р зүйлийг “Компанийн болон охин компанийн эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих” болгон өөрчлөхөөр тус тус хэлэлцэн тогтлоо.

Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлаар нийт өгсөн саналын тоо 75,000 ширхэг, үүнээс зөвшөөрсөн 100%, татгалзсан 0%, түдгэлзсэн 0%, нийт саналын эрхийн 90.5 хувийн саналаар уг шийдвэрийг баталлаа.

Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталж Санхүүгийн Зохицуулах Хороо, Хөрөнгийн Бирж ХК-д хүргүүлэхээр шийдвэрлэв.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинэчлэн сонгох тухай асуудлаар нийт өгсөн саналын тоо 75,000 ширхэг, үүнээс зөвшөөрсөн 100%, татгалзсан 0%, түдгэлзсэн 0%, нийт саналын эрхийн 90.5 хувийн саналаар уг шийдвэрийг баталсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохдоо кумулятив аргыг ашигласан ба ердийн гишүүнээр:

1. А.Хадбаатар
2. Б.Пүрэвжаргал
3. Б.Сугарсүрэн
4. Б.Насан-Эрдэнэ
5. Б.Одмаа
6. Э.Болор-Эрдэнэ

Хараат бус гишүүнээр:

1. С.Отгонбилэг

2. Г.Мөнхбаяр
3. О.Нандинчимэг нарыг сонголоо.

Төлөөлөн удирдах зөвлөлийн сар бүрийн төсөв 9,600,000 төгрөг байх бөгөөд үүнд ТУЗ-ийн гишүүний сарын цалин 1,000,000 төгрөг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын сарын цалин 500,000 төгрөг, сар бүрийн Хангамжийн зардал 100,000 төгрөг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлах асуудлаар нийт өгсөн саналын тоо 75,000 ширхэг, үүнээс зөвшөөрсөн 100%, татгалзсан 0%, түдгэлзсэн 0%, нийт саналын эрхийн 90.5 хувийн саналаар уг шийдвэрийг баталсан байна.

Хурлаар хэлэлцэх асуудалд орсон 2022 оны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг Хурлын дарга Б.Сугарсүрэн хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

“Манай компанийн стратегийн үндсэн зорилго нь таваарын экспортын тэргүүлэгч компани болох билээ. Энэхүү зорилгынхоо хүрээнд үе шаттайгаар компанийн үйл ажиллагааг өргөжүүлж төрөл бүрийн таваарын үйлдвэрлэлийг эхлүүлэн ажиллана. Анхны төсөл нь хушны самрын идээний экспорт байх бол 2 дахь төсөл нь олон улсын стандартын дагуу боловсруулсан монгол малын махны экспортын төсөл байх юм. Хушны самрын төслийн бий болгосон санхүүжилтийн схем, төслийн бүтцийг ашиглан энэхүү төслийг хэрэгжүүлнэ” гэж мэдэгдлээ.

Хурлын даргын танилцуулсан 2022 оны Бизнес төлөвлөгөөг Хувьцаа эзэмшигчид сайшааж буйгаа илэрхийлснээр хурал өндөрлөв.

Хурлын дарга хурлыг хаав.

Хурал: 17:10 цагт өндөрлөв.

Хурлын дарга: /Б.Сугарсүрэн/

Тэмдэглэл хөтөлсөн: /Ж.Үүрийнтуяа/

